



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/159

Баян-Өндөр сум

Сумын аварга шалгаруулах журам
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын аварга шалгаруулах журмыг хавсралтаар баталсугай.
2. Сумын аварга, оны тэргүүнээр шалгаруулахаар өргөн мэдүүлсэн этгээдийн анкетийг хоёрдугаар хавсралтаар баталсугай
3. Сумын аварга, оны тэргүүнээр шалгаруулахаар өргөн мэдүүлсэн этгээдийн тооцооны хуудсыг гуравдугаар хавсралтаар баталсугай.
4. Батлагдсан журмын дагуу сумын аварга, оны тэргүүнийг шалгаруулахыг Засаг даргын зөвлөлд даалгасугай.
5. Сумын аварга оны тэргүүнээр нэр дэвшүүлэхээр иргэн, аж ахуй нэгж байгууллагын журманд заасны дагуу материалыг бүрдүүлэн өгч ажиллахыг байгууллагын дарга, эрхлэгч, аж ахуй нэгж, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА

С.ЧУЛУУНШАГАЙ

Сумын Засаг даргын 2014 оны 12 сарын
21 өдрийн 2153 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН АВАРГА, ОНЫ ШИЛДЭГ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Журмын зорилго

1.1. Сумын нийгэм эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж тухайн салбар нэгждээ болон эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан иргэн аж ахуйн нэгж, байгууллагыг сумын хэмжээнд жил бүр шалгаруулж, шагнаж урамшуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Журамд өөрчлөлт оруулах асуудлыг Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлын саналаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

Хоёр: Ерөнхий зүйл:

2.1. Нэр дэвшигч нь холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар хураамжаа бүрэн төлсөн, гэмт хэрэгт ял шийтгэгдээгүй, зөрчлийн хэрэгт шийтгэгдээгүй байна.

2.2. Нэр дэвшигч нь хүмүүнлэгийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцож Монголын Улаан загалмайн Нийгэмлэгийн татвар төлсөн байна.

2.3. Хариуцсан ажилдаа санаачлага гарган идэвхитэй ажиллаж бусдыгаа манлайлсан байна.

Гурав: Дүгнэх үзүүлэлтүүд

3.1. "Оны Тэргүүний байгууллага" Төсвийн байгууллагууд хамаарна. Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн төв, Соёлын төв, ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, цаг уурын станц хамаарна. Сум орон нутгийн хөгжилд нэмэр болохуйц нэгээс доошгүй бүтээлч ажил тухайн жилдээ хийсэн байх, төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй хөнгөн шуурхай хүргэж чанар хүртээмжийг дээшлүүлсэн байх, өөрийн байгууллагад хөрөнгө оруулалт авч үр ашигтай зарцуулсан байх, ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдэхэд тодорхой ахиц гаргасан байх, төсөв, санхүү, татвар, шимтгэл даатгал, тайлан мэдээний зөрчилгүй байх, байгууллага нь ажлын үзүүлэлтээрээ салбар нэгждээ дундаас дээгүүр орсон байх, сумаас зохиосон ажилд хамт олноороо идэвхитэй оролцдог байх, байгууллагын дотоод ажил сайн, албан бичиг баримт заавар журмын дагуу хөтлөгдсөн байх, жилийн ажлын үзүүлэлтээр хөндлөнгийн шалгалтаар хангалттай үнэлгээ авсан байх.

3.2. "Оны Шилдэг төрийн албан хаагч" Төрд ажиллаж байгаа төрийн захиргааны болон үйлчилгээний салбарын багш, эмч, мэргэжилтнүүд хамаарна. Тухайн байгууллагад тогтвор суурьшилтай 3 доошгүй жил ажилласан байх. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт хангалттай түвшинд дүгнэглсэн байх, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилгүй байх, иргэд, хамт олны дунд нэр хүндтэй идэвхи санаачлагатай үр бүтээлтэй ажиллаж төрийн үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай хүргэдэг байх, тухайн жилийн онцлогоос шалтгаалан 2 албан хаагч шалгаруулж болно. (жил бүр шалгаруулах шаардлагагүй) Сумын оны шилдэг төрийн албан хаагчийн шагналыг жил бүр шинэ жилийн арга хэмжээн дээр гардуулна. Оны шилдэг төрийн албан хаагчийн шагнал нь мөнгөн шагнал, үнэ бүхий зүйлээс бүрдэнэ.

3.3. **"Оны шилдэг удирдах ажилтан"** 2 жилд нэг удаа шалгаруулна. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, ерөнхий боловсролын сургуулийн захирал, менежер, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, соёлын төвийн эрхлэгч, эрүүл мэндийн төвийн дарга, цаг уурын өртөөний эрхлэгч хамаарна. Байгууллагын хүний нөөцийн дутагдалгүй, шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажилласан байх. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж төсвийн ил тод байдлыг хангаж өр авлагагүй ажилласан байх. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилгүй байх. Иргэд хамт олны дунд нэр хүндтэй идэвхи санаачилгатай үр бүтээлтэй ажиллаж төрийн үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай хүргэдэг байх.

3.4. **"Оны онцлох сурагч"** Суралцах явцдаа нийгмийн идэвх оролцоогоороо бусдыгаа маналайлж, өөрийн авъяас чадвараа бусадтайгаа хуваалцдаг, багаар ажиллах удирдан чиглүүлэх чадвартай, олон нийтийн ажилд идэвхитэй оролцдог байх. Оны онцлох сурагчийг тодруулахдаа хүүхдийн өөрөө удирдах байгууллагын саналаар шалгаруулж Ерөнхий боловсролын сургууль тодорхойлон жилд 2 сурагч (Бага болон дунд ангиас тус бүр нэг хүүхэд) шалгаруулна. Тухайн жилийн амжилтыг харгалзана.

3.5. **Оны Шилдэг өрхийн үйлдвэрлэгч:** (жил бүр шалгаруулах шаардлагагүй) Сум орон нутгийн хөгжилд нэмэр болохуйц үйлдвэрлэл үйлчилгээгээ 3-аас доошгүй жил эрхэлсэн байх. Үйлдвэрлэл үйлчилгээний чанар хэрэглэгчдийн таашаалд нийцсэн байх. Ажлын байр шинээр бий болгосон байх. Олон нийтийг хамарсан уралдаан тэмцээнийг 1-ээс доошгүй удаа ивээн тэтгэсэн буюу зорилтод өрхөд дэмжлэг үзүүлсэн байх. Татвар хураамжийг хугацаанд нь бүрэн төлдөг байх. Сум хөгжүүлэх сангаас зээл авсан бол зээл, зээлийн хүүг хугацаанд төлсөн хугацаа хэтэрсэн зээлгүй байх.

3.6. **"Оны шилдэг баг, тамирчин"** Мэргэжлийн холбоодын тодорхойлолтыг үндэслэн тухайн онд гаргасан сум, аймаг, бүс, улс, олон улсын чанартай тэмцээний амжилтыг харгалзана.

3.7. **Оны тэргүүний хувийн хэвшил:** банк, шатахуун түгээх станц, хоршоо, мал эмнэлэг, аж ахуйн нэгж гэх мэт хувийн хэвшлийн бүх байгууллагууд хамаарна. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь тасралтгүй олон нийтэд хүрсэн байх. Олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн чуулга уулзалтыг ивээн тэтгэдэг байх. зорилтод өрх, иргэнд дэмжлэг туслалцаа үзүүлсэн байх.

3.8. **Оны Шилдэг ажилтан:** Бүх төрийн үйлчилгээний ажилчид, шуудан, эрчим хүч, холбооны салбар хамаарна.

Тус байгууллагад 3-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажилласан байх. Ажлын үзүүлэлт нь хангалттай сайн түвшинд дүгнэгдсэн, ажлын байран дээрээ шинэ санал, санаачилга гаргасан байх, ёс зүйн зөрчилгүй байх.

3.9. **Оны шилдэг нийгэмд үйлчилэх төрийн бус байгууллага:** Тус суманд үйл ажиллагаа явуулдаг бүх холбоод, зөвлөл хамаарна. Тухайн онд санаачилан хэрэгжүүлсэн ажил иргэд олон нийтэд таашаалтайгаар хүрсэн байх, тэдний дэмжлэгийг авсан байх, сайн үйлсийн арга хэмжээнд нэгдсэн байхыг шаардана. Хийсэн ажлын тайлангаа суманд ирүүлсэн байх.

3.10. **Оны шилдэг уяач**

Улс, аймаг, бүс, сумын баяр наадмын амжилтийг харгалзан олгоно. Сумын тахилгатай овооны уралдааны амжилтийг оруулж болно. Жил бүр шалгаруулах шаардлагагүй.

3.11. **Оны шилдэг уралдаанч хүүхэд** Улс, аймаг, бүс, сумын баяр наадмын амжилтийг харгалзан олгоно. Сумын тахилгатай овооны уралдааны амжилтийг

оруулж болно. Жил бүр шалгаруулахгүй байж болно. Оны шилдэг уралдаанч хүүхдийн шагналыг Уяачдын холбооны арга хэмжээн дээр гардуулна.

3.12. “Урлаг, спортын салбарын оны шилдэг хүүхэд” Улс, аймаг, олон улсын тэмцээн уралдаанд оролцож амжилт гаргасан байдлыг харгалзана.

3.13. “Сумын аварга малчин” Сүүлийн гурван жилд малаа төрлөөр нь тасралтгүй өсгөж малгүй буюу мал цөөтэй нэгээс доошгүй өрхийг малжуулахад тусалсан байх, сүргийн бүтцийг байгаль цаг уур, бэлчээрийн байдалтай уялдуулан зохистой хэмжээнд байлгаж хээлтэгчийн тоог урьд оныхоос бууруулаагүй байх, ноогдол татвар хураамжийг тогтмол төлдөг байх, малын ашиг шимийг бүрэн ашигладаг байх, худаг ус, хороо бууц, нутагласан газрын ариун цэвэр, тохижилтийг сайжруулж засварласан байх, хадлан тэжээлийн зохих нөөцтэй байх, зорилтод өрхөд тусласан байх, тухайн жилд сум орон нутгаас зохион байгуулсан ажилд нийгмийн идэвхи гарган оролцож хандив тусламж өгсөн байх. Тухайн жилийн намрын багийн иргэдийн нийтийн хурлаар нэр дэвшүүлж хэлэлцүүлнэ. Сумын аварга малчны шагналыг жил бүр хаврын тэргүүн сарыг угтаж гардуулна.

3.14. “Тэргүүний тариаланч, хадланч” жил бүр шалгаруулах шаардлагагүй/. Сүүлийн гурван жилд дараалан тариалан эрхэлж хувийн хэрэгцээнээс гадна иргэд, байгууллагуудад худалдан борлуулж өрхийн орлогоо нэмэгдүүлсэн байх, өндөр сортын үрийг/ ялангуяа/ төмс нутагшуулан тариалж га-гаас авах ургацыг жил дараалан нэмэгдүүлсэн байх, хөрсийг химийн бус аргаар бордож сайжруулсан байх, тариалалт арчилгаа хадгалалт боловсруулалтад орчин үеийн дэвшилтэт технологи нэвтэрсэн байх, ажлын байр шинээр бий болгоход анхаарсан байх. Сумын аварга тариаланч, хадланчийн шагналыг жил бүр хаврын тэргүүн сарыг угтаж гардуулна.

Дөрөв: Дүгнэх журам:

4.1. Оны шилдэг / сумын аварга/-аар шалгаруулах шаардлага хангасан иргэдийн ажил байдлын тодорхойлолтыг байгууллага, баг, ААН-ийн удирдлагууд хамт олны хурлаар хэлэлцүүлж материалыг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ. Засаг даргын орлогч ирсэн материалд холбогдох чиглэл хариуцсан ажилтан татвар, даатгал, байгаль орчин, цагдаа гэх мэтээр/ санал дүгнэлт гаргуулж сумын Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

4.2. Бүрдүүлэх материал хамт олны хурлын тэмдэглэл, ажил байдлын тодорхойлолт, нийгмийн даатгал, татвар, МУЗН-ийн татвар төлсөн баримт, цагдаагийн байгууллагын тодорхойлолт, хандив өгсөн баримт зэргийг бүрдүүлнэ. Материал дутуу бол хүлээн авахгүй. Сумын аварга, оны шилдгүүдийн холбогдох материалыг 12 дугаар сарын 15-ны хүлээн авна. Хугацаа хоцорсон материалыг хүлээн авахгүй.

4.3. Материалд нэр дэвшигчийн ажлын амжилтыг үнэн зөв тусгасан байна.


Тав: Олгох урамшуулал

Сумын аварга буюу “ОНЫ ШИЛДЭГ”-ээр шалгарсан байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, малчин, төрийн албан хаагч, ажилтныг урамшуулах хөрөнгийг ЗДТГазар бүрэн хариуцана.

Сумын Засаг даргын 2022 оны 12 сарын
21 өдрийн 0/159 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт

СУМЫН АВАРГА ОНЫ ТЭРГҮҮНЭЭР ШАГНУУЛАХААР ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН ХҮНИЙ АНКЕТ

1. Овог
2. Нэр:
3. Төрсөн он
4. Хүйс:
5. Төрсөн аймаг, сум, хот:
6. Одоогийн харьяалал:
7. Нийгмийн байдал:
8. Регистр №
9. Боловсрол:
10. Ажилладаг салбар:
11. Мэргэжил:
12. Урьд болон одоо ажиллаж байгаа газар:



№	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил
1.			
2.			
3.			

13. Урьд нь шагнагдаж байсан шагналууд:

№	Шагналын нэр	Хэдэн онд
1.		
2.		
3.		

14. Шагнуулах үндэс:
15. Ямар шагналаар шагнуулах хамт олны санал:
16. Хамт олны саналын хувь:
17. Хурлын тэмдэглэл заавал хавсаргах.

БАЙГУУЛЛАГЫН ДАРГЫН ГАРЫН ҮСЭГ ГАРЫН ҮСГИЙН ТАЙЛАЛ

Сумын Засаг даргын 2022 оны 12 сарын
21 өдрийн 1/159 дугаар захирамжийн
3 дугаар хавсралт

СУМЫН АВАРГА, ОНЫ ТЭРГҮҮНЭЭР ШАГНУУЛАХААР ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН ХҮНИЙ ТООЦООНЫ ХУУДАС

Дэс дугаар	Тавигдах шаардлага	Тайлбар	Баталгаажуулалт	Баталгаажуулсан албан тушаалтны нэр
1	Улаан загалмайн татвар төлсөн эсэх			
2	Хандив тусламж өгсөн эсэх			
3	Нийгмийн даатгал төлсөн эсэх			
4	Эрүүл мэндийн даатгал төлсөн эсэх			
5	Малын тоо толгойн албан татвар төлсөн эсэх			
6	Бусад татвар, хураамж төлсөн эсэх			
7	Өөрийн хэрэгцээнд тэжээл тариалсан эсэх			
8	Өвөлжөө, хаваржаандаа жорлон, муу усны нүхтэй эсэх			
9	Бусдыг ажлын байраар хангасан эсэх			
10	Гэмт хэрэг, зөрчлийн хэрэгт шийтгэгдсэн эсэх			
11	Сахилгын шийтгэлтэй эсэх			

Тайлбар: Зарим шаардлага нь сумын аварга малчидаас бусад этгээдэд бөглөгдөхгүй
байж болно. Баталгаажуулсан албан тушаалтан батлагааны үнэн зөвийг бүрэн
хариуцна. Хэрэв худал баталгаа гаргасан тохиолдолд албан тушаалтан хариуцлага
хүлээх үндэслэл болно. -